

Адуунчулуун ХК-ийн 2017 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлан

2017 оны эхний хагас жилд 260.0 мян.тн нүүрс олборлох, 500.0 мян.м³ хөрс хуулах, нийт 718.5 мян.м³ уулын цулын ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөснөөс нүүрс 286.6 тн, хөрс хуулалт 350.7 мян.м³, уулын цул 591.5 мян.м³-ын гүйцэтгэлтэй гарсан.

Үзүүлэлт	Х/нэгж	2017-II		зөрүү	
		төлөвлөгөө	гүйцэтгэл	биетээр	%-р
Нүүрс борлуулалт	мян.тн	260.0	286.6	26.6	110
“ДБЭХС” ХК	мян.тн	235.0	258.6	23.6	110
Ахуй	мян.тн	25.0	28.0	3.0	112
Хөрс хуулалт	мян.м3	500.0	350.7	-149.3	70
Уулын цул	мян.м3	718.5	591.5	-126.9	82

Нүүрс олборлолт, борлуулалт-хэрэглэгчээр

260.0 мян.тн нүүрс олборлож, борлуулах төлөвлөгөө 110 хувьтай биелсэн. Үүнд ДБЭХС ТӨХК-д төлөвлөгөө ёсоор 235.0 мян.тн нүүрс нийлүүлэхээс 258.6 мян.тн-ыг нийлүүлж төлөвлөгөөг 23.6 мян.тн-р, ахуйн хэрэглэгчдэд төлөвлөгөө ёсоор 25.0 мян.тн нүүрс нийлүүлэхээс 28.0 мян.тн-ыг нийлүүлж төлөвлөгөөг 3.0 мян.тн-р тус тус давуулан биелүүлж, нийт дүнгээр 26.6 мян.тн-р нүүрсний төлөвлөгөө давж биелсэн байна.

Сар бүр 180.0 мян.тн нүүрсний шилжих нөөцтэй байх төлөвлөгөөтэй ажилласнаас 6-р сарын 30-ны байдлаар 150 мян.тн авахад бэлэн нүүрсний нөөцтэй шилжсэн.

Биологийн нөхөн сэргээлт 4.0 га-д хийгдэхээс 2.1 га-д, техникийн нөхөн сэргээлт 7.0-га-д хийгдэхээс 4.0 га-д тус тус хийгдэж байна.

Үндсэн үйлдвэрлэл, уулын ажил

2017 оны бүтэц, орон тоогоор 156 байнгын ажлын байранд 156 ажилтан албан хаагчидтай ажиллаж байна.

Компани уулын хэсэг, автозасварын хэсэг, цахилгаан сантехникийн хэсэг гэсэн үйлдвэрлэлийн үндсэн 3 хэсэгтэй. Энэ 3 хэсэгт 2017 оны эхний хагас жилийн байдлаар нийт 52 ажил төлөвлөгдсөнөөс 35 ажил нь бүрэн хийгдэж 67 хувийн

биелэлттэй гарсан. Техник тоног төхөөрөмж, авто машинуудын их засварын ажил бүрэн хийгдсэн.

Тухайлбал ЭКГ-4,6Б маркийн №784, 986, ЭКГ-5А маркийн №8690,10982-ын жилийн их засварын ажлууд бүгд хийгдсэн, технологийн автомашин Dong-Feng, Faw, Howo автосамосвалуудад их засвар болон урсгал засваруудыг графикийн дагуу хийсэн, зам усалгааны усны белаз-35, кразын хөдөлгүүр, коробка, усны насосанд засвар үйлчилгээг цаг тухайд нь хийж зам усалгаа, галын аюулаас урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангуулж ажилласан.

Мөн авто тээврийн хэрэгслүүдийг улсын үзлэгт оруулж, техник оношлогоонд бүрэн хамруулсан.

ЛЭП-8 агаарын шугамын хуучин эргэлтийн анкерыг бетонон шонгоор сольж тавьсан, консервацын гражийн дулааны шугамыг шинээр татаж холбосон. Конторын хүйтэн усны шугамыг сольж шинээр татсан, напорын якорь 1-ийг засварласан, клонкын ерөнхий тэжээл, дотор монтажийг сэргээн шинэчилсэн.

Санхүү, эдийн засгийн үзүүлэлт

Тайлант хугацаанд нийт 4449.8 сая.төг-ийн орлого орж, 3713.2 сая.төг-ийн зардал гаргаж ажилласан. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал орлого 435.2 сая.төг буюу 10.8%-иар, зардал 441.9 сая.төг буюу 13.5%-иар тус тус өссөн. Татвар төлөхийн өмнөх ашиг өнгөрсөн оноос 6.7 сая.төг-р буурсан.

Өнгөрсөн онтой харьцуулахад нийт зардал 441.9 сая.төг-р өссөн. Үүнээс үндсэн үйлдвэрлэлийн зардал 403.2 сая.төг-р, удирдлагын зардал 13.1 сая.төг-р, үйл ажиллагааны бус бусад зардал 25.6 сая.төг-р тус тус өссөн байна.

Үйл ажиллагааны зардал дотор түлш 11.5%, сэлбэг 24.9%, цалин 26.0%, элэгдэл 9.4%, бусад зардал 28.2%-ыг эзэлж байна.

1 тн нүүрсний өртөг 2016 оны эхний хагас жилд 12596.5 төгрөг байсан бол тайлант хугацаанд 12956.0 төгрөг болж 359.6 төгрөгөөр өссөн байна.

Нийт авлага 2558.4 сая.төг, богино хугацаат өр төлбөр 267.4 сая.төг, урт хугацаат өр төлбөр байхгүй.

2017 оны 4-р сарын 13-нд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулсан. Нэгж хувьцаанд 120 төгрөгийн ногдол ашиг зарлаж, нийт дүнгээр 378.2 сая.төг-ийн ногдол ашиг хувиарласан.

Тайлан бичсэн: Эдийн засагч

Б.Тэнгис